



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 01/2022

Хажуу шинэ үс

Сумын өмч хамгаалах байнгын
зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн
байгуулах тухай

Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 01сарын 24-ний өдөр 06 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Орон нутгийн өмчийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалт, ашиглалтанд хяналт тавих, эд хөрөнгө олж авах, бүртгэх, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах устгах, данснаас хасах зэргээр эд хөрөнгө зохицуулалт, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг судалж зөвлөмж, дүгнэлт гаргаж ажиллах үүрэг бүхий сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Н.Ганбат	(Санхүү албаны дарга)
Нарийн бичиг	Д.Жаргалмаа	(ИТХ-ын нарийн бичгийн дарга)
Гишүүн	Д.Сарангэрэл	(Засаг даргын орлогч)
Гишүүн	Г.Булган	(Нийгмийн даатгалын байцаагч)
Гишүүн	Д.Алтансаргай	(Татварын улсын байцаагч)

2.Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон Сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг мөрдлөг болгон сум орон нутагт хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3.Сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлийн дарга (Н.Ганбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ө.МӨНХ-АМГАЛАН

